



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх зарим арга
хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2017 онд 13 аймгийн 70 сум, нийслэлийн 5 дүүрэгт нийт 225 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, 120.9 мянган га ой, 466.5 мянган га хээр, нийт 587,4 мянган га талбай түймэрт өртөж, иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөнд 77.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Түймрийн нөхцөл байдлыг 2016 онтой харьцуулахад түймэрт хүний амь нас эрсдээгүй, түймэрт өртсөн эд материалын хохирол, түймэрт өртөж шатсан талбайн хэмжээ буурсан боловч, түймрийн тоо 63 хувь, байгаль, экологид учирсан хохирол 5.3 дахин тус тус өсчээ.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2018 оны 3, 4, 5 дугаар саруудад нийт бүс нутгаар хуурайшилт эрчимтэй явагдаж ялангуяа ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй Сүхбаатар, Дорнод аймагт 0.5-1.5 градусаар, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгуудын нутгаар 0.5-1.0 градусаар олон жилийн дунджаас илүү халж, хур тунадас багатай гэсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээлэл ирүүлсэн нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өнөөдрийн байдлаар 2018 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Дорнод аймаг Баян-Уул суманд 1 удаа хээрийн гал түймэр гарч 2100 га талбай шатсан нь зарим аймаг, сумдад хур тунадас багатай, хуурайшилттай түймрийн гаралт, давтамж нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

Иймд Улсын Онцгой комиссын “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах АЛБАН ДААЛГАВРЫГ хүргүүлж байна.

Нэг. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын
дарга нарт ДААЛГАХ нь:

1. Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлд заасны дагуу ой, хээрийн гал түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө, төсвийг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавих.

2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.19, Ойн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх, унтраах сургалт, дадлагыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

3. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар бүлэг 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/346 дугаар тушаалаар "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг ажиллуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын "Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх тухай" албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжилтэд хяналт тавин, тайлан мэдээг тогтоосон хугацаанд ирүүлэх.

5. Объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журам, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтран гаргасан А/16, А10 дугаартай тушаал, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 04, А/126 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллах.

6. Бүсийн төвийн дарга нар онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан "Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсүүд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн нөхцөлд түймэр унтраах ажиллагаанд хамтран ажиллах хуваарь"-ийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллах.

7. Бүсийн төвийн дарга нарт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, албаны бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажиллах.

8. Бие бүрэлдэхүүний албаны мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, сургалт сурталчилгаа явуулах, дадлага сургалтыг аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой зохион байгуулах

9. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга нар ой, хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах хүн хүч, техник хэрэгслийг тооцон, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх алба хаагчдыг томилгоожуулж, хүн нэг бүрийн аранз, автомашин, тоног төхөөрөмж, бүх төрлийн багаж хэрэгслийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.

10. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллах 1 бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж офицероор ахлуулан, байршил тодорхойлогч /GPS/, сансарын холбооны хэрэгслээр /IRIDIUM/ болон байр зүйн зургаар хангаж, түймрийн голомтод очсон үед газар орон, цаг агаарын нөхцөл байдал, түймрийн шатлагын га талбай, солбилцолыг үнэн зөв, шуурхай тодорхойлж мэдээлэх.

11. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд болон зуны хэт халалтын үед тухайн бүс нутгийн түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль орчинтой харьцах үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь хязгаарлах.

12. Ой, хээрийн гал түймрийн дуудлагыг хүлээн авсан албан тушаалтан болон дуудлага хүлээн авагч нь /оператор/ цаг агаарын болон гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газарт цаг алдалгүй шуурхай мэдээлэх.

13. Төв, орон нутагт гарсан ой, хээрийн гал түймрийн бүртгэл судалгааг хагас, бүтэн жилээр нэгтгэн үнэн зөв хөтөлж, Гал түймэртэй тэмцэх газарт тогтмол хүргүүлж байх, шаардлагатай тохиолдолд тухай бүр шуурхай ирүүлэх.

14. Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын улирал, зуны хэт халалтын үед иргэд, олон нийтэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, сурталчилгаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Хоёр. Аврах тусгай ангийн захирагчид ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллах автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, шатахууны бэлэн байдлыг хангуулж, нөөцийг бүрдүүлэх.

2. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангуулах, шүхрийн зааварлагч, шүхэрчин гал сөнөөгчдийн шүхрийн буултын дадлагыг зохион байгуулах

3. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг шуурхай илрүүлэх, унтраах сургалт, дадлагыг орчин үеийн шинэ технологи хэрэгсэл, нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийг ашиглан явуулах.

Гурав. Хангалт үйлчилгээний ангийн захирагчид ДААЛГАХ нь:

1. Гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай сэлбэг, шатах, тослох материалаар тасралтгүй хангаж, нөөцийг бүрдүүлэн, жолооч, автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах.

Албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд төв, орон нутаг, харьяа анги байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, тайланг 06 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 15-ны дотор нэгтгэн дүгнэж, танилцуулахыг Тэргүүн дэд дарга /штабын дарга/ /бригадын генерал Г.Ариунбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ